

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ  
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны  
06 дугаар сарын 20-ны өдрийн 7/112  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг нь хүүхэд хамгааллын ойлголтын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц болон Монгол Улсын нэгдэн орсон бусад холбогдох олон улсын гэрээ, конвенц, мөн түүнчлэн үндэсний хууль тогтоомжоор 18 нас хүрээгүй хүн бүрийн эрхийг хангана.

### Хоёр.Зорилго

2.1.ЦДҮС ТӨХК нь өөрийн үйл ажиллагаа болон ажилтнуудаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хүүхдийг хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд энэхүү хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн зорилго чиглэгдэнэ.

### Гурав.Үндсэн зарчмууд

3.1.Хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэртэй хэзээ ч эвлэрэхгүй байж, хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учруулах хүнийг хүүхэдтэй хамт амьдрах, хамт ажиллахад зөвшөөрөхгүй байхад анхаарна.

3.2.Аливаа үйл ажиллагаанд хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдалд оруулж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, учирч болзошгүй хор нөлөө, сөрөг үр дагаврыг багасгах, арилгахад байнга анхаарч ажиллана.

### Дөрөв.Хамрах хүрээ

4.1.Энэхүү баримт бичиг нь компанийн үндсэн болон гэрээт ажилтан, түүний гэр бүлийн гишүүд, харилцагч байгууллагуудад хамаарна.

### Тав.Хэрэгжүүлэх заавар

5.1.ЦДҮС ТӨХК, компанийн төв удирдлага, салбарууд нь хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулж, дараах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1.Хүүхэд хамгааллын талаар урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.

5.1.2.Хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан тохиолдолд тухайн ажилтан гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн байгууллага, цагдаагийн байгууллагатай холбогдон мэдээлэх, зуучлах арга хэмжээ авч ажиллана.

## 5.2. Зохион байгуулалт.

5.2.1. Төв удирдлага, салбарын удирдах албан тушаалтан, ажилтнуудын төлөөлөл бүхий “Эцэг эхийн салбар зөвлөлүүд” нь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөг жил бүр төлөвлөн батлуулж, зохион байгуулна. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг нийт ажилтанд байнга сурталчилна.

## 5.3. Урьдчилан сэргийлэх.

5.3.1. Ажилтнуудад хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцааны чиглэлээр сургалт явуулна.

5.3.2. Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн талаар хууль эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлэл өгч, сургалт явуулна.

5.3.3. Хүүхэд хамгааллын асуудлаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж мэргэжил, арга зүйн дэмжлэг тусалцаа авна.

## 5.4. Ажилтан сонгон шалгаруулж ажилд авахад дараах асуудлыг анхаарах.

5.4.1. Ажилд орох хүсэлт гаргагчийг хоёроос дээш жилийн хугацаанд таних хоёр хүнээс зан байдлын тодорхойлолт гаргуулсан байхыг шаардана. Гэр бүлийн гишүүн байж болохгүй. Тодорхойлолтыг гаргуулахдаа Хавсралт 1-ыг ашиглана.

## 5.5. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм баримтлах

5.5.1. Нийт ажилтнууд болон шинээр ажилд орж байгаа ажилтан, албан хаагчид “Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм”-тэй танилцан гарын үсэг зурж гэрээ байгуулна. Хавсралт 2-ыг ашиглана.

## 5.6. Эрсдэлийг бууруулах.

5.6.1. Компанийн нь үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг ханган аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллана.

## 5.7. Зөрчлийг мэдээлэх, мэдээлэл хүлээн авах үүрэг

5.7.1. Ажилтан бүр хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн талаар компанийн удирдлага, эцэг эхийн зөвлөлд мэдээлэх үүрэгтэй.

5.7.2. Компанийн эцэг эхийн салбар зөвлөлүүд хүүхэд хамгааллын зөрчлийг мэдээлэх, мэдээлэл хүлээн авах үүрэгтэй.

5.7.3. Орон нутаг, тодорхой газар хүүхдийн аюулгүй байдал алдагдсан, хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн болон өртсөн байж болзошгүй талаар мэдээллийг хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу өгнө.

5.7.4. Мэдээлэгчийн нууцлалыг хадгалан, мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангана.

## 5.8. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах

5.8.1. Компани нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийн мөрөөр ажиллахдаа хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалахын тулд хүчин чармайлтаа гарган ажиллана.

5.8.1.1. Шуурхай үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээнд холбон зуучлахдаа уг үйл ажиллагааны улмаас хүүхдийг дахин хохирогч болгохгүй байхад онцгой анхааран ажиллана.

5.8.1.2. Бүх мэдээллийн нууцыг хадгалж, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэнэ.

- 5.8.1.3.Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлсэн нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангана.
- 5.8.2.Хэрэв тухай асуудал нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол дараах арга хэмжээг авна.
- 5.8.2.1.Хуулийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллага, хамтарсан багт яаралтай мэдэгдэнэ.
- 5.8.2.2.Хуулийн байгууллага болон орон нутгийн эрх бүхий хүүхэд хамгааллын байгууллагаас нь хэргийн явцын болон хэрхэн шийдвэрлэсэн талаарх эцсийн мэдээллийг авдаг байна.
- 5.8.3.Хэрэв тухай асуудал нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол дараах арга хэмжээг авна.
- 5.8.3.1.Буруутай этгээдийн асуудлыг байгууллагын дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.
- 5.8.3.2.Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх шаардлагатай бол орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага болон мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучилна.

### **Зургаа.Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм**

6.1.Хүүхэд хамгааллын ёс зүйн зүйн дүрмийн гол зорилго нь хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад орших бөгөөд байгууллагын ажилтны зүгээс хүүхэд хамгааллын хувьд эрсдэлтэй, зохисгүй зан үйл гаргахгүй байхад чиглэнэ.

#### **6.2.Зөвшөөрөх**

- 6.2.1.Харилцааны зөв үлгэр дуурайлал үзүүлэх;
- 6.2.2.Хүмүүжлийн эерэг аргыг ашиглах;
- 6.2.3.Хүүхдийн хувийн нууцыг задруулахгүй байх, аливаа мэдээллийн хэрэгслээр хүүхдийн тухай мэдээллийг дамжуулахдаа тэдний эрх ашгийг нэн тэргүүнд дээдэлнэ. Зураг авах, видео бичлэг хийхээс өмнө ажилтан бүр хүүхдийн эмзэг байдалд мэдрэмжтэй хандаж, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээлэл нь тэдний аюулгүй байдал, эрх ашигт хэрхэн нөлөөлж болохыг нягтлах, хүндэтгэлтэй хандах;
- 6.2.4.Хүүхдийг ашигласан садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг бусад зүйлсийг хэрэглэхгүй байх, ийм зүйлсээс татгалзах;
- 6.2.5.Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг хүлээн зөвшөөрдөггүй, мэдээллийг нуун дарагдуулдаггүй соёлыг байгууллага, хамт олонд төлөвшүүлэх;
- 6.2.6.Аливаа үйл ажиллагааг явуулахдаа хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болзошгүй бүхий л эрсдэлийг тооцох, сэргийлэх;
- 6.2.7.Хүүхдийн дунд гарч болзошгүй дээрэлхэлт, дарамт, хүчирхийллээс сэргийлэх
- 6.2.8.Хүүхдийг хөдөлмөрийн, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн золиос болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах

#### **6.3.Хориглох**

- 6.3.1.Хүүхдэд дээрэнгүй хандах;
- 6.3.2.Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх;
- 6.3.3.Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх;

- 6.3.4.Хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох, бэлгийн харилцаанд уруу татах, биеийг үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэл үйлдэх;  
6.3.5.Хүүхдийг бэлгийн харилцаанд өдсөн, садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг яриа ярих зэргээр биеэ авч явах, бусдад тийм боломж олгох;  
6.3.6.Хууль бус эсвэл хүүхдэд аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд түүнийг тоохгүй орхих;  
6.3.7.Хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх;  
6.3.8.Хүүхдийг ямар нэг байдлаар нь ялгаварлан харилцах

**Долоо.Ажилтнуудыг эцэг эхийн үүргээ биелүүлэхэд  
дэмжлэг үзүүлэх**

7.1.Эцэг эх болон хүүхэд асран хамгаалагч ажилтнуудад эцэг эхийн үүргээ биелүүлэх, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгох талаар анхаарч ажиллана.

7.2.Компани нь гэр бүл, эцэг эхийг дэмжиж туслах талаар ажлын төлөвлөгөөтэй байна.

Хавсралтууд:

Хавсралт 1 “Тодорхойлолтын загвар”

Хавсралт 2 “Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсөн гэрээ”

Хавсралт 3 “Нэр томъёоны тайлбар”

--О--

ЗАН БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ ГАРГУУЛАХ  
ХҮМҮҮСИЙН ХАЯГ

Таны зан байдлын талаар тодорхойлолт өгөх боломжтой таныг хоёр жилээс дээш хугацаагаар таних хоёр хүний нэр, холбоо барих хаягийг бичнэ үү. (Гэр бүлийн гишүүдийг оруулахгүй)

Тодорхойлогч 1

|                    |  |
|--------------------|--|
| Нэр:               |  |
| Гэрийн хаяг:       |  |
| Утас, и-мэйл хаяг: |  |

Тодорхойлогч 2

|                    |  |
|--------------------|--|
| Нэр:               |  |
| Гэрийн хаяг:       |  |
| Утас, и-мэйл хаяг: |  |

ЦДҮС ТӨХК

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ХҮЛЭЭН  
ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

20 ..... оны ..... сарын ..... өдөр

..... -НЫ ..... би  
ЦДҮС ТӨХК-ийн “Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг”-т дурдсан “Ёс зүйн  
дүрэм”-ийг уншиж ойлголоо. Би дурдсан зарчмуудыг хүлээн зөвшөөрч тус  
байгууллагад ажиллаж байх хугацаандаа хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг сахиж  
ажиллана.

.....  
(нэр)

.....  
(албан тушаал)

.....  
(гарын үсэг)

**НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР:**

1.Хүүхэд: 18 нас хүртэлх хүн<sup>1</sup>

2.Хүүхэд хамгаалал<sup>2</sup>: Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

3.Хүүхдэд ээлтэй байгууллага: Бие махбод, сэтгэл санааны, бэлгийн болон үл хайхрах хүчирхийллээс (байдлаас) хүүхдийг хамгаалах үзэл санаа, үйл ажиллагааг өөрийн байгууллагын бүх түвшинд нэвтрүүлсэн, дадал болгосон, дотоод журамдаа тусгасан, байгууллагын соёлд нэвт шингээсэн байгууллагыг хэлнэ.

4.Хүүхэд хамгааллын бодлого: Хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг. Үүнд хүүхэд бүрд аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгасан байна.

5.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд<sup>3</sup>: Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд

6.Хүүхдийн эсрэг хүчирхийлэл<sup>4</sup>: Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах, үйл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтын хэлнэ. Хүчирхийллийн хэлбэр:

- бие махбодын хүчирхийлэл
- сэтгэл санааны хүчирхийлэл
- бэлгийн хүчирхийлэл
- үл хайхрах

7.Бие махбодын хүчирхийлэл: Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх зорилгоор хэн нэгэнд этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед халдсаныг эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэрэг

8.Үл хайхрах: Зохистой хоол унд, хувцас, орон байр, эмнэлгийн тусламж боловсрол эзэмших зэрэг хүүхдийн үндсэн хэрэгцээг хангаж чадахгүй байх

9.Сэтгэл санааны хүчирхийлэл: Асран хамгаалагчийн зүгээс хүүхдийг үнэ цэнгүй, согогтой, чамд хэн ч хайргүй, чамтай хамт байхыг хэн ч хүсэхгүй гэж ойлгуулах, айлган сүрдүүлэх, хэл амаар доромжлох, загнах, гутаах зэрэг үйлдэл юм.

10.Бэлгийн хүчирхийлэл: Хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан, энэхүү нөхцөлд байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэрэг

11.Хүүхдийг садар самуунд ашиглах<sup>5</sup>: Бэлгийн амьдралыг харуулан дүрслэн бичсэн бичлэг, видео бичлэг, зураг бүтээхдээ хүүхдийг оролцуулах үйлдэл

12.Мөлжлөг: Хүүхдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг хүнд хөдөлмөр эрхлүүлэх, садар самуун болон бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татан ашиг олох үйлдэл

13.Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ<sup>6</sup>: Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа

---

<sup>1</sup> НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын 1 дүгээр заалт

<sup>2</sup> МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг

<sup>3</sup> МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт

<sup>4</sup> МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт

<sup>5</sup> МУ-ын Эрүүгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэг

<sup>6</sup> МУ-ын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ  
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны  
..... дугаар сарын .....-ны өдрийн А/Н  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЦДҮС ТӨХК-ийн эцэг эхийн салбар зөвлөлүүдийн 2025-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

| №                                                                                                                                                                           | Үйл ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Хүрэх түвшин /үр дүн/                                                    | Шаардагдах төсөв | Хугацаа                        | Хариуцах салбар зөвлөл           |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|------------------|--------------------------------|----------------------------------|
| Нэг. Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дүгээр зүйлийн 43.3 дахь заалтын дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр: |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                          |                  |                                |                                  |
| 1.1                                                                                                                                                                         | "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангуулах                                                                                                                                                                                                                                                                                                                   | Батлагдсан "ЦДҮС ТӨХК-ийн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг"                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал | -                | 2025.06-р сар                  | Төв удирдлагын эцэг эхийн зөвлөл |
| 1.2                                                                                                                                                                         | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүрийн гишүүнээ асран халамжилдаг жирэмсэн, хөхүүл эмэгтэй, цэцэрлэгийн болон сургуулийн бага ангийн хүүхэдтэй ажилтнуудын өглөө ажилдаа ирэх, орой ажлаас тарах цагийг уян хатан байдлаар зохицуулах, мөн ажилтанд хүүхдийнх нь төрсөн өдрөөр болон "School police" хийсэн өдөр цалинтай чөлөө олгох, эдгээр асуудлыг хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд тусгуулах, хэрэгжүүлэх | Хүүхдийнх нь төрсөн өдрөөр цалинтай чөлөө олгосон ажилтны тоо<br>Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүрийн гишүүнээ асран халамжилдаг ажилтан, жирэмсэн, хөхүүл эмэгтэй болон цэцэрлэгийн болон сургуулийн бага ангийн хүүхэдтэй ажилтны өглөө ажилдаа ирэх, орой ажлаас тарах цагийг уян хатан байдлаар зохицуулах ажилтны тоо<br>"School police" чөлөө олгосон хүний тоо<br>Бусад дэмжлэгт хамруулсан ажилтны тоо | Салбар зөвлөлүүд үйл ажиллагаандаа ашиглана. Бодлого хэрэгжинэ.          | -                | 2025.12-р сар<br>2026.12-р сар | Бүх салбар зөвлөлүүд             |
| Хоёр: Компанийн ажилтнуудын гэр бүл болон хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих чиглэлээр                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                          |                  |                                |                                  |
| 2.1                                                                                                                                                                         | Компанийн ажилтнуудын 18 хүртэлх насны хүүхдийн дэлгэрэнгүй судалгаа гаргах, нэгтгэх                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | 18 хүртэлх насны хүүхдийн тоо                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                          | -                | 2025.07-08-р сар               | Бүх салбар зөвлөлүүд             |

|     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                             |                                                                                                                                         |                                                                          |                                |                                                     |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|--------------------------------|-----------------------------------------------------|
| 2.2 | Төв удирдлага болон салбаруудын төв оффист ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан "Хүүхдийн өрөө" байгуулах, /Энэ ажилд хамтрах олон улсын болон сайн дурын бусад байгууллагуудтай хамтран ажиллах бололцоог судлах, хэрэгжүүлэх/ "Хүүхдийн өрөө"-ний үйл ажиллагааг хүүхдүүдийг нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хөтөлбөр гарган зохион байгуулах                                 | Байгуулсан<br>"Хүүхдийн өрөө"                                               | Салбар зөвлөлүүд үйл ажиллагаандаа ашиглана. Бодлого хэрэгжинэ.                                                                         | Үйлдвэрчний эвлэлийн хороодууд, нийт ажилтнууд, сайн дурын байгууллагууд | 2025-2026 он                   | Бүх салбар зөвлөлүүд                                |
| 2.3 | Хүүхдэд зориулсан спортын хөтөлбөрийг гаргах, хэрэгжүүлж ажиллах                                                                                                                                                                                                                                                                                                              | Хэрэгжүүлсэн хөтөлбөр болон хамрагдсан хүүхдийн тоо                         | Салбар зөвлөлүүд үйл ажиллагаандаа ашиглана. Бодлого хэрэгжинэ.                                                                         | -                                                                        | 2025-2026 он                   | Төв удирдлагын эцэг, эхийн зөвлөл                   |
| 2.4 | Жил бүрийн 6-р сарын 01-ний өдөр буюу "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах" өдрийг тохиолдуулан компанийн ажилтнуудын хүүхдүүдэд зориулан "Хүүхдийн баяр"-ын арга хэмжээг зохион байгуулах                                                                                                                                                                                   | Хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо                                           |                                                                                                                                         | Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороодууд                                 | 2025.05-р сар<br>2026.05-р сар | Бүх салбар зөвлөлүүд                                |
| 2.5 | Хүүхдүүдэд мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор "Мэргэжил бүхэн сайхан" сэдэвт ажлын байртай танилцуулах арга хэмжээг 14-16 насны хүүхдүүдийн дунд зохион байгуулах                                                                                                                                                                                                   | Арга хэмжээний тоо, хамрагдсан хүүхдүүдийн тоо                              |                                                                                                                                         | -                                                                        | 2025.09-р сар<br>2026.04-р сар | Бүх салбар зөвлөлүүд                                |
| 2.6 | Ажилтнуудын гэр бүл, хүүхдүүдийн дунд хамтарсан тэмцээн уралдаан, өдөрлөг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах                                                                                                                                                                                                                                                          | Гэр бүл, хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга хэмжээний тоо                       | Хүүхдүүдэд мэргэжилээ сонгоход дэмжлэг болно, тэдний мэргэжлийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэнэ                                        | Үйлдвэрчний эвлэлийн хороодууд                                           | 2025.11-р сар<br>2026.09-р сар | Бүх салбар зөвлөлүүд                                |
| 2.7 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аяны хүрээнд "Бүх нийтээр мод тарих өдөр" болон "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан компанийн захиргаа, эцэг эхийн зөвлөлөөс эцэг эхчүүдийг хүүхдүүдтэй нь хамт эрүүл агаарт мод тарих боломж нөхцөлөөр хангах. Энэ ажлыг цаашид уламжлал болгон зохион байгуулахад анхаарах | Өдөрлөгт хамрагдсан эцэг, эх, хүүхдийн тоо, тарьсан мод болон суулгачын тоо | Гэр бүлд эерэг харилцаа бий болно. Эх дэлхийгээ хайрлан хамгаалах төлөвлөлийг хүүхдэд олгох болон танин мэдэхүйн чухал ач холбогдолтой. | Үйлдвэрчний эвлэлийн хороодууд                                           | 2025, 2026 он                  | Төв удирдлагын эцэг, эхийн зөвлөл, салбар зөвлөлүүд |



|     |                                                                                                              |                                                                  |                                                                                                                                                                                                                    |   |                                                                  |                      |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|------------------------------------------------------------------|----------------------|
| 4.1 | "Эцэг эхийн зөвлөл"-ийн хийсэн ажлын тайланг хамт олны хуралд танилцуулж, санал хүсэлтийг хүлээн авч ажиллах | Гэр бүл, хүүхэд хамгааллын талаар ажилчдад нэгдсэн ойлголт өгөх  | Сайн ажилласан эцэг эхийн салбар зөвлөлийн гишүүдийг Гүйцэтгэх захирлын болон Салбарын даргын нэрэмжит мөнгөн шагнал болон бусад шагналаар шагнах, жилд нэг удаа тав хүртэл хоногийн цалинтай чөлөөгөөр урамшуулах | - | 2025.12-р сар<br>2026.12-р сар                                   | Бүх салбар зөвлөлүүд |
| 4.2 | Үйл ажиллагааны тайлангаа орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар/ хэлтэст хүргүүлэх        | Хэрэгжилтийн хувь                                                | Тайланг хагас бүтэн жилээр хүргүүлсэн байна.                                                                                                                                                                       | - | 2025.07-р сар<br>2026.01-р сар<br>2026.07-р сар<br>2027.01-р сар | Бүх салбар зөвлөлүүд |
| 4.3 | Үйл ажиллагааны орлого, зарлагыг хөтлөх                                                                      | Нэгдсэн тооцоотой болох                                          | Тооцоо ил тод, шилэн байх                                                                                                                                                                                          | - | 2025.12-р сар<br>2026.12-р сар                                   | Бүх салбар зөвлөлүүд |
| 4.4 | Бизнес төлөвлөгөөнд эцэг эхийн зөвлөлийн дараагийн жилийн үйл ажиллагааны зардалыг тусгуулах                 | Эцэг эхийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаагаанд дэмжлэг болно. | Бодлого хэрэгжинэ                                                                                                                                                                                                  | - | 2025.12-р сар<br>2026.12-р сар                                   | Бүх салбар зөвлөлүүд |

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Б.ЭРХЭМЗАЯА

ТӨВ УДИРДЛАГЫН ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Э.БОЛОР-ЭРДЭНЭ

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Я.БАТТОГТОХ

БОЛОВСРУУЛЖ, НЭГТГЭСЭН:

ТӨВ УДИРДЛАГЫН ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Б.СОЛОНГО